



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 155

Улаанбаатар хот

Гашуунсухайт боомтоор нэвтрэх
ачаа тээврийг нэмэгдүүлэх
арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хилийн Гашуунсухайт боомт дахь “Автомат удирдлагатай чингэлэг тээврийн терминал”-ын ухаалаг гарцаар жолоочтой ачаа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлж, ачаа тээвэрлэлтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Гаалийн ерөнхий газар (Р.Отгонжаргал), Хилийн боомтын захиргаа (Б.Батхишиг), “Эрдэнэс Тавантолгой” ХК (Х.Мөнхжаргал) нарт даалгасугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга Б.Тулга нарт үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ДЭЛГЭРСАЙХАН